



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/235

Булган сум

**Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2.1 дэхь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан “Автогридер худалдан авах (Баян-Агт сум)” нийлүүлэгчээр шалгарсан “Намдэмүн сервис” ХХК-тай 198,000,000 (нэг зуун ерэн найман сая) төгрөгөөр гэрээ байгуулж, барааны нийлүүлэлтийн гүйцэтгэлд холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Баян-Агт сумын Засаг дарга (Б.Бямбажав)-д үүрэг болгосугай.

2.Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Намдэмүн сервис” ХХК-ийн захирал (Ж.Лхагвасүрэн)-д үүрэг болгосугай.

3.Хөрөнгийг данс бүртгэлд бүртгэж хөрөнгө ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихыг Баян-Агт сумын Засаг дарга (Б.Бямбажав)-д үүрэг болгосугай.


4.Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2025 оны  
04 дүгээр сарын 15-ний өдрийн  
А/235 дугаар захирамжийн хавсралт



| Д/д | Нөхцөл шаардлага      | Мөнгөн дүн   | Хариуцах албан тушаалтан |
|-----|-----------------------|--|--------------------------|
| 1   | 2                     | 3  | 4                        |
| 1   | Алданги               | Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна | Д.Батцогт                |
| 2   | Гүйцэтгэлийн баталгаа | Гэрээний үнийн дүнгийн 3 хувь  | Д.Батцогт                |
| 3   | Чанарын баталгаа      | Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана.  | Д.Батцогт<br>Б.Бямбажав  |
| 4   | Баталгаат хугацаа     | 1 жил  | Б.Бямбажав               |